

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛСАН
АЖЛЫН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2021.06.28

Улаанбаатар хот

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт 2021 оны эхний хагас жилийн байдлаар 84 өргөдөл, гомдол албан хаагчид болон иргэд, ААН-ээс бичгээр ирүүлснийг хүлээн авч “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-ийн дагуу шийдвэрлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа. Нийт 84 санал хүсэлт, өргөдөл гомдол ирсний 73 өргөдлийг шийдвэрлэсэн, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 14 цаг 46 минут, өргөдөл гомдлын индексийн үзүүлэлт “В” үнэлгээтэй байна. Шийдвэрлэх шатандаа судлагдаж байгаа хүсэлт, өргөдөл 11, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн өргөдөл байхгүй болно.

Газрын орлогч даргын баталсан 2021 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн дотоод хяналт шалгалт хийх ажлын удирдамжийн дагуу нийт албан хаагчдын албан хэрэг хөтлөлт, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд дотоод хяналт шалгалт хийж тодорхой зөрчил дутагдлыг илрүүлж тухай бүр арга хэмжээ авч, шаардлагатай гэж үзсэн зөрчил дутагдал дээр сахилгын шийтгэл ногдуулж ажилласан. Мөн газрын даргын “Хэрэгжилтийг ханган ажиллах тухай” 2021 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дугаартай албан даалгаврын 2.6-д “Нийт албан хаагчид албан хэрэг хөтлөлтийн стандартыг баримтлан, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд онцгой анхаарч зөрчилгүй ажиллах”-ийг даалган үүрэгжүүлэн ажиллаж байна. */Албан даалгаврыг хавсаргав./*

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой судалж, шийдвэрлэхэд хугацаа шаардагдах дараах өргөдлүүд байсан. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр шинэ Коронавируст халдвар (COVID-19) цар тахлаас сэргийлэх, тархалтыг бууруулах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хөл хорио тогтоосонтой холбогдуулан нийслэлийн өмчийн байр, талбайг түрээслэгчид /Урт цагаан үйлчилгээний төвд үйл ажиллагаа эрхэлж байсан иргэдийг Засаг захиргааны 4 дүгээр байранд шилжүүлж, түрээсийн гэрээг шинэчлэн байгуулсан, Сургууль цэцэрлэгийн үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид/ хорио цээрийн хугацаанд түрээсийн төлбөрөөс чөлөөлүүлэх тухай санал, хүсэлт ирүүлсэн байна.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар захирамжаар Нийслэлийн төр захиргааны IV байрны түрээслэгч, Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлэгч түрээслэгчийн түрээсийн төлбөрийг 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл чөлөөлөөд байна.


Хүсэлт

- Түрээсийн гэрээ, түрээсийн төлбөртэй холбоотой 33
- Тээврийн хэрэгслийн дуудлага худалдаатай холбоотой 12,
- Архивын лавлагаа, мэдээлэл хүссэн 6
- Тэтгэвэр тэтгэмж, тусламж олгох, ажлаас чөлөө хүсэх, ажлаас чөлөөлөгдөх зэрэг хүний нөөцтэй холбоотой 16
- Бусад 17

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал:

Д/Д	Хэлтэс	Шийдвэрлэлт			Нийт	Шийдвэрлэлтийн хувь
		Шийдвэрлэгдсэн	Судлагдаж байгаа	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн.		
1	Удирдлага	1	2	-	3	33,3%
2	Захиргаа санхүүгийн хэлтэс	32	6	-	38	84,2%
3	Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс	2	-	-	2	100%
4	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс	2	-	-	2	100%
5	Өмчийн мэдээлэл хяналт, ашиглалтын хэлтэс	36	3	-	39	92,3%
	Нийт	73	11	-	84	87%

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг сүүлийн 2 жилийн мөн үетэй харьцуулбал:



Өргөдөл гомдолд хариу өгсөн хэлбэр:

Хариу өгсөн хэлбэр			
Программ+мессеж	Программ+ мессеж+утсаар	Программ+	мессеж+албан


28	11	бичиг	34
----	----	-------	----

Өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдлын тайлан:

Ангилал		
Иргэний талд шийдвэрлэсэн	Боломжгүй тухай хариу өгсөн	Бусад
44	14	15

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа

№		Өргөдлийн тоо	Хувь
1	5 хоногт шийдвэрлэсэн	34	46.58%
2	10 хоногт шийдвэрлэсэн	20	27.40%
3	15 хоногт шийдвэрлэсэн	11	15.07%
4	30 хоногт шийдвэрлэсэн	8	10.96%
5	Хугацаа сунгаж шийдвэрлэсэн	-	-
6	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	-	-
Нийт		73	100%




Зөрчлийн тоон үзүүлэлт

д/д	Зөрчлийн төрөл	2020 он	2021 он
1	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	1	3
2	Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчлийн тоо	21	5
3	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил	49	24
Зөрчлийн тоо		71	32

Тодорхой арга хэмжээг авч ажилсны үр дүнд зөрчлийн үзүүлэлт өмнөх оноос 54%-иар багассан байна. (2020 эхний хагас жилд 71 байсан бол 2021 оны мөн үед 32 (55%) болж багассан байна. 32 зөрчлийн 26-г буюу 81%-ийг байгууллагын удирдлага үүсгэжээ.)

Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хугацааг сар бүрээр харьцуулбал:



Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хугацааг хэлтэс бүрээр харуулбал:

- Захиргаа, санхүүгийн хэлтэс -32, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 15 цаг 56 минут
- Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс -2, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 1 цаг 25 минут
- Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс -2, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 7 цаг 31 минут
- Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын хэлтэс -36, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 14 цаг 41 минут.

ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГА М.БАЯРАА

ХЯНАСАН:

ОРЛОГЧ ДАРГА Н.МӨНХБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ЗСХ-ИЙН ДАРГА Б.БАТБАЯР

ЗСХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.УУГАНЦЭЦЭГ